

ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТӨВИЙН
2021 ОНЫ ҮЙЛ АЖИЛДЛАГААНД ХИЙСЭН ХЭРЭГЛЭГЧИЙН
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2021 ОН

АГУУЛГЫН ТОМЬЁОГ

СУДАЛГААНЫ ЕРАНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Судалгаа хийх үндэслэл

Судалгааны зорилго, хүрэх үр дүн

Судалгааны арга, түүвэр, оролцогч

Судалгааны ашиглагдсан аргуудын тайлбар

НЭГДҮГЭЭР ХЭСЭГ: Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж

1.1 Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл үзүүлэх үйлчилгээнд хийсэн шинжилгээ

ХОЁРДУГААР ХЭСЭГ: Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөл шүүх байгууллагаас авсан судалгаа

ГУРАВДУГААР ХЭСЭГ: Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөл прокурорын байгууллагаас авсан судалгаа

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаа болон удирдлагийн сэтгэл ханамж

ТАВДУГААР ХЭСЭГ . Дүгнэлт, зөвлөмж

5.1 Хууль зүйн туслалцааны төвийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд өмнөх онуудад тавьсан эрхэм зорилгод хүрч чадсан эсэх

5.2 Бодлогын зөвлөмж

Судалгааны ерөнхий мэдээлэл

Судалгаа хийх үндэслэл:

Хэрэглэгчийн үнэлгээг Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ийн дагуу Хууль зүйн туслалцааны төвийн 2021 оны үйл ажиллагаанд Хэрэглэгчийн үнэлгээ хийлгэх хөндлөнгийн байгууллагын сонгон шалгаруулалт шалгарсан “Ардчилал судлалын хүрээлэн” НҮТББ нь судалгааг хараат бус байдлыг баримтлан, зөвхөн судалгаа, шинжилгээгээр тогтоосон үр дүнд үндэслэн гүйцэтгэв.

Судалгааны зорилго, хүрэх үр дүн

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны хүрээнд дараах зорилтыг тавьсан.
Үүнд:

1. Төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагчийн хувиар Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчөөр үйлчлүүлсэн иргэний сэтгэл ханамжийг үнэлэх
2. Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчөөс хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл авсан иргэдийн сэтгэл ханамжийг үнэлэх
3. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг иргэдэд хүргэхэд тулгарч буй бэрхшээлүүд болон тэдгээрийн шалтгааныг илрүүлэх
4. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны өнөөгийн нөхцл байдалд үнэлэлт дүгнэлт өгөх
5. Хөндлөнгийн судалгааны үр дүнд үндэслэн хууль зүйн туслалцааны төвийн ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх санал, зөвлөмжийг боловсруулах

Хэрэглэгчийн үнэлгээний судалгааны тайлан нь Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг сайжруулах, тус төв нь иргэдэд илүү үр дүнд хүрч үйлчлэх боломжийг нэмэгдүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулна гэж үзэж байна.

Судалгааны арга, түүвэр, оролцогчид

Хуульзүйн туслалцааны төвийн 2021 оны үйл ажиллагаанд хэрэглэгчийн үнэлгээний судалгааг хийж гүйцэтгэхдээ баримт бичиг, социологийн, ганцарчилсан ярилцалгын болон анкетын судалгааны арга болон тоон судалгааны аргуудыг ашигласан.

Судалгаанд ашиглагдсан аргуудын тайлбар

Тус судалгаанд Улаанбаатар хотын 9 дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүх болон прокурорын байгууллага, Цагдаагийн газрын төлөөлөл, улсын хэмжээнд аймаг, дүүрэгт өмгөөлөлийн үйл ажиллагаа явуулж буй улсын өмгөөлөгчид, улсын хэмжээнд хууль зүйн зөвлөгөө, туслалцаа авсан иргэдийн түүвэрлэн хамруулсан.

Судалгааны мэдээллийг цуглуулахдаа үйлчлүүлэгчээс авах асуумж, хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөлтэй хийх ганцаарчилсан ярилцлага, баримт бичгийн судалгаа зэрэг тоон болон чанарын судалгааны аргуудыг ашиглав.

Анкетийн арга

Анкет нь олон нийтийн санаа бодол, хүсэл эрмэлзлэл, хандлага, үнэлгээг тодорхойлоход хамгийн тохиромжтой нийгмийн судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн арга билээ. Тиймээс энэхүү судалгаанд анкетийн аргаар иргэд хууль зүйн туслалцааны төвөөр үйлчилгээнд өгч буй үнэлгээ, үйлчлүүлэх явцад тулгардаг бэрхшээл, мэдээлэл авч буй байдал, түүнийг сайжруулах арга замын талаарх санал бодол гэх мэт судалгааны зорилго, зорилтыг хангах бүхий л мэдээллүүдийг цуглуулна. Цар тахалтай холбоотой хүндрэл гарсан тохиолдолд судалгааны ажилд хүндрэл гаргахгүй тулд утсаар мэдээлэл цуглуулах бүрэн боломжтой.

Судалгаанд нийт 1 төрлийн анкет хэрэглэнэ. Үүнд:

- Зорилтот буюу хууль зүйн туслалцааны төвөөр үйлчлүүлж буй иргэдээс мэдээлэл цуглуулах анкет;

Ганцаарчилсан ярилцлагын арга

Энэ нь чанарын судалгааны мэдээлэл цуглуулах үндсэн арга билээ. Ганцаарчилсан ярилцлагын арга нь анкетийн аргаар авсан мэдээллийн учир шалтгаан, мөн чанар, дотоод зүй тогтлыг илэрхийлэн гаргахад ихээхэн үр дүнтэй байдаг. Тиймээс энэхүү судалгаанд ганцаарчилсан ярилцлагын аргаар анкетийн судалгааны мэдээллийг гүнзгийрүүлэн шалгах, учир шалтгааныг нь тодорхойлох мэдээллүүдийг цуглуулна. Дараах субъектүүдээс ганцаарчилсан ярилцлагын аргаар мэдээлэл цуглуулна. Үүнд:

1. Хууль зүйн туслалцааны төвөөр үйлчлүүлсэн иргэн
 - I. Зөвлөгөө авсан иргэн
 - II. Улсын өмгөөлөгчөөр үйлчлүүлсэн сэжигтэн, шүүгдэгч, яллагдагч
 - III. Хууль зүйн туслалцаа авсан орон нутгийн иргэн
2. Хууль зүйн туслалцааны төвтэй хамтын ажиллагаа бүхий байгууллагын ажилтан

Цар тахлын улмаас биечлэн уулзах боломжгүй иргэнээс утас болон бусад цахим хэргэсэл ашиглан судалгааны мэдээлэл авч хийх

Баримт бичгийн шинжилгээний арга

Баримт бичиг судлах буюу шинжлэх арга нь объектив шинжтэй учраас судлаачдад илүү бодитой мэдээлэл өгнө. Энэхүү судалгаанд холбогдох дараах баримт бичгүүдэд шинжилгээ хийхээр төлөвлөж байна. Үүнд:

- Өмнөх жилүүдийн хөндлөнгийн үнэлгээ болон судалгаанд холбогдох статистик, тоо, мэдээ, үйл ажиллагааны тайлан зэрэгт тус тус шинжилгээ хийхээр төлөвлөж байна

Мэдээлэл боловсруулалт

- Судалгааны явцад цуглуулсан мэдээллийг Excel програмд шивж нэгтгээд, логик алдааг магадлан, мэдээллийн санг цэвэрлэсний эцэст тоон мэдээллийн шинжилгээний SPSS (Statistical Programm for Social Science) 20.0 програмыг ашиглан боловсруулалт хийнэ.
- Чанарын судалгааны мэдээллийг энгийн нэгтгэлийн аргаар хэв маягчлал үүсгэн категорчилж, судалгааны үр дүнг боловсруулж, нэгтгэнэ.

Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны ерөнхий мэдээлэл

Монгол улсын Үндсэн хуульд зааснаар хүн өөрийгөө өмгөөлөх, эсвэл мэргэжлийн өмгөөлөгч авч хууль зүйн туслалцаа авч болно. Өөрийгөө өмгөөлөхдөө мэдээлэл авах, хүсэлт, гомдол, тайлбар гаргах, тодорхой ажиллагаанд биечлэн оролцох боломжоор хангагдах ёстой.

Хууль зүйн туслалцааны төв нь гэмт хэрэг үйлдсэн сэжигтэн, яллагдагч, хэргийн оролцогч хэн боловч эрх бүхий байгууллагаас эрх авсан мэргэжлийн өмгөөлөгчөөр өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах үүднээс хэрэг маргаан, эд материалын хариуцлага болон бусад нөхцлүүдийг цагаатгах, хөнгөрүүлэх, өөрийн гэм бурууг үгүйсгэх нотлох баримтыг гаргах, цуглуулахыг шаардах, хуулийн зүйл заалтыг өөрт ашигтайгаар тайлбарлах зэрэг үйл ажиллагаанд иргэний эрх ашгийг хамгаалж ажилладаг.

Мэргэжлийн өмгөөлөгч нь тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохдоо өмгөөллийн туслалцаа үзүүлж буй өмгөөлүүлэгчийн ашиг сонирхлыг нэн тэргүүнд тавихаас гадна мэргэжлийн өндөр ёс зүйтэй байхыг шаарддаг. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.6 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх, прокурор, мөрдөгч нь яллагдагч өөрийгөө өмгөөлөх, эсхүл өмгөөлүүлэх, хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх боломжоор ханганах” гэж хуульчилжээ. Энэ эрхийг баталгаатай эдлүүлэхийн тулд сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, хохирогч өмгөөлөгчөө сонгон аваагүй бол түүний хүсэлтээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд өмгөөлөгч оролцох боломжийг хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүх хангах бөгөөд өмгөөлөгчөө сонгоход нь тодорхой хүний нэр зааж болохгүй гэсэн хориглосон заалтыг мөн хуульчилсан байна.

Хууль зүйн туслалцааны төв дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

1. Эрүүгийн хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх хүрээнд:
 - тухайн нутаг дэвсгэр дээр үйлдэгдсэн гэмт хэргийн холбогдогч төлбөрийн чадваргүй иргэний өргөдөл, хүсэлтийг хүлээн авах
 - төлбөрийн чадваргүй нь тогтоогдсон иргэнд эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны бүхий л шатанд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх
 - харьяаллын бус өргөдөл, хүсэлтийг холбогдох байгууллагад нь шилжүүлэх

Нэгдүгээр хэсэг. Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж

1.2 Төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл үзүүлэх үйлчилгээнд хийсэн шинжилгээ

Төлбөрийн чадваргүй иргэнд үзүүлэх хууль зүйн туслалцааны төвийг үйл ажиллагааг 21 аймаг, 9 дүүргээс зөвлөгөө үйлчилгээ авсан иргэдээс түүвэрлэн нэг салбараас 2 хүн санамсаргүй байдлаар сонгон орон нутгийн үйлчлүүлэгчтэй утсаар холбогдон 9 дүүргийн иргэдтэй ганцаарчилсан уулзалтын аргаар судалгааг авсан судалгааг анкетын аргаар авсан

Оролцогсдын ерөнхий мэдээлэл:

Нийт 55 хүний ерөнхий мэдээллийг хүйс, нас, боловсрол, хөдөлмөр эрхлэлттэй гэсэн хэмжээс тавьж асуусан. SPSS-ын програмд оруулсан үр дүнгээ хүснэгтээр үзүүлж байна.

Хүснэгт 5. Оролцогсдын нас

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	18-аас доош	6	10.9	10.9	10.9
	18-25 нас	2	3.6	3.6	14.5
	26-35 нас	26	47.3	47.3	61.8
	36-45 нас	9	16.4	16.4	78.2
	46-55 нас	7	12.7	12.7	90.9
	56-аас дээш	5	9.1	9.1	100.0
	Total		55	100.0	100.0

18-аас доош насны иргэдийн зөвлөгөө авсан / эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигт/ нараас судалгаа авсан болно

Хүснэгт 6. Боловсролын төвшин

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Боловсролгүй	3	5.5	5.5	5.5
	Бүрэн бус	33	60.0	60.0	65.5
	Бүрэн дунд	5	9.1	9.1	74.5
	Тусгай дунд	2	3.6	3.6	78.2
	дээд	12	21.8	21.8	100.0
	Total		55	100.0	100.0

Боловсролгүй буюу бичиг үсэг мэдэхгүй иргэн 3 байна.

Хүснэгт 7. Ажил, хөдөлмөр эрхлэлт

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Хувиараа	8	14.5	14.5	14.5
	Тэтгэвэр, халамж	5	9.1	9.1	23.6
	Ажилгүй	21	38.2	38.2	61.8
	Оюутан/Сурагч	6	10.9	10.9	72.7
	Бусад	6	10.9	10.9	83.6
	Төрийн албан хаагч	6	10.9	10.9	94.5
	Малчин	3	5.5	5.5	100.0
	Total	55	100.0	100.0	

Ажил эрхлэлтийн байдлыг хархад дийлэх нь ажилгүй буюу амьжиргааны төвшин доогуур иргэд байна. Үндэсний статистикийн хороо, нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран баталсан аргачлалын дагуу өрхийн мэдээллийн нэгдсэн санд орсон, амьжиргааны төвшин нь тухайн үеийн ядуурлын шугамаас доогуур өрхийн гишүүн нэгдсэн санд бүртгэлгүй боловч ядуурлын шугамаас доогуур орлоготой болохоо тодорхойлсон хүнийг төлбөрийн чадваргүй амьжиргааны төвшин доогуур гэж үзэж байна.

Төлбөрийн чадваргүй иргэд дийлэнх нь бүрэн бус боловсролтой, ажилгүй иргэд байна. Мөн зарим иргэн бичиг үсгийн мэдлэггүй улмаас өөрийгөө өмгөөлөх, өмгөөлөгч сонгох боломжгүй нөхцөл байдал үүсч байна.

1.3 Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаанд иргэдийн сэтгэл ханамж

Хүснэгт 8. Хэрэг, маргааны аль талын оролцогч

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Хохирогч, нэхэмжлэгч	17	30.9	30.9	30.9
	Сэжигтэн, шүүгдэгч, яллагдагч, хариуцагч	38	69.1	69.1	100.0
	Total	55	100.0	100.0	

Хүснэгт 9. Зөвлөгөө авсан төрөл

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Эрүүгийн хэрэг	47	47.3	47.3	47.3
	Иргэний маргаан	8	52.7	52.7	100.0
	Total	55	100.0	100.0	

Эрүүгийн шүүхээр хэргээр шүүн таслах ажиллагаа явагдсаны дараа иргэний журмаар хохирол нөхөн төлсөн болон төлүүлсэн иргэд туслалцаа үзүүлсэн.

Хүснэгт 10. Хэрэг маргаан гархаас өмнө ХЗТТ-ийн үйл ажиллагааг мэддэг байсан эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	3	5.5	5.5	5.5
	үгүй	52	94.5	94.5	100.0
	Total	55	100.0	100.0	

Дийлэнх хувь нь хэрэгт холбогдхоосоо өмнө ямар нэгэн байдлаар улсын өмгөөлөгч төлбөрийн чадваргүй буюу өмгөөлөгчийн төлбөр төлөх боломжгүй иргэдийн эрх ашгийг хамгаалах үйл ажиллагаа явуулдаг тав байгууллага, өмгөөлөгч байдаг төлөөр ямар нэгэн мэдээлэлгүй байсан байна.

Хүснэгт 11. Та улсын өмгөөлөгчийн талаарх мэдээллийг анх хаанаас авсан

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	www.lac.gov.mn	3	5.5	5.5	5.5
	Найз нөхөд	9	16.4	16.4	21.8
	Гэр бүлийн орчин	8	14.5	14.5	36.4
	Хороо, багийн захиргааны ажилтнуудаас	3	5.5	5.5	41.8
	Цагдаагийн байгууллагаас	26	47.3	47.3	89.1
	Өмгөөллийн товчоо	4	7.3	7.3	96.4
	Бусад	2	3.6	3.6	100.0
	Total	55	100.0	100.0	

Дээрх судалгаанаас хархад Цагдаагийн байгууллагаас улсын өмгөөлөгчийн талаар мэдээлэл авсан иргэд ихэнх нь байна.

Хүснэгт 12. Танд өмгөөллийн үйлчилгээг түргэн шуурхай үзүүлсэн үү

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш сайн	55	100.0	100.0	100.0

Хүснэгт 13. Танд хэрэг, маргааны талаар хангалттай мэдээлэл өгсөн үү

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш сайн	55	100.0	100.0	100.0

Хүснэгт 14. Танд улсын өмгөөлөгчийн мэдлэг ур, чадварын хувьд өндөр төвшинд байсан эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш сайн	55	100.0	100.0	100.0

Дээрх асуудалд зарим иргэд өмнөн олон өмгөөлөгчтэй харицаж үзээгүй ямар өмгөөлөгчийг мэдлэгтэй, ур чадвартай гэдгийг сайн мэдэхгүй байна. Надад тулгарсан асуудлыг шийдвэрлэж өгсөн болхоор маш сайн гэж хувьдаа бодож байгаа талаар хэлсэн.

Хүснэгт 15. Таны асуудалд оновчтой зөвлөгөө өгч чадсан эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш сайн	55	100.0	100.0	100.0

Хүснэгт 16. Харилцаа, хандлага хувьд найрсаг байсан эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш сайн	55	100.0	100.0	100.0

Хүснэгт 17. Асуудалд ашиг сонирхолын зөрчилгүй шудрага зарчмын дагуу хандсан эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш сайн	55	100.0	100.0	100.0

Хүснэгт 18. Хууль зүйн туслалцааны төвөөр үйлчлэхэд бэрхшээлтэй байгаа эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	үгүй	55	100.0	100.0	100.0

Дээрх хүснэгт 12-18 дахь хэсгээс хархад улсын өмгөөлөгч төлбөрийн чалваргүй үйлчлүүлэгчид үйлчилгээг маш чанартай үзүүлдэг бөгөөд улсын өмгөөлөгчид итгэх иргэдийн итгэл маш өндөр төвшинд байна. Мөн улсын өмгөөлөгч тухай иргэнийг төлбөрийн чадваргүй улмаас ямар нэгэн байдлаар хэрэгт хайхрамжгүй хандалгүй иргэдэд чин сэтгэлээс хариуцлагатай хандсаж эрх, хууль ёсны ашиг сонирхолын хамгаалж байна.

Хүснэгт 19. Та улсын өмгөөлөгчийг сонгож зөвлөгөө авах болсон шалтгаан

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Төлбөртэй өмгөөлөгч авах боломжгүй учраас	35	63.6	63.6	63.6
	Өмгөөлөгчдийг чадварлаг гэж бодсон учраас	3	5.5	5.5	69.1
	Цагдаагаас санал болгосон учраас	12	21.8	21.8	90.9
	Санаандгүй үйлчилүүлсэн	5	9.1	9.1	100.0
	Total	55	100.0	100.0	

Цагдаагийн байгууллагаас санал болгосон учраас улсын өмгөөлөгч сонгосон иргэд олон хувийг эзэлж байна.

Хүснэгт 20. Хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгчийн үйл ажиллагаа, үйлчилгээг цаашид сайжруулах талаар таны санал хүсэлт

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	Мэдэхгүй байна	9	16.4	16.4	16.4
	Хэлэх санал байхгүй	23	41.8	41.8	58.2
	Өмгөөлөгчийн ажиллах орчинг сайжруулах	10	18.2	18.2	76.4
	Орон тоог нэмэгдүүлэх	5	9.1	9.1	85.5
	Өмгөөлөгчийн урсгал зардлыг хангах	8	14.5	14.5	100.0
	Total	55	100.0	100.0	

Хэлэх санал байхгүй иргэдийн дийлэнх хувь нь өмгөөлөгчийн үйл ажиллагаа ямар байдаг болон ямар байх талаар нарийн үйл ажиллагааны талаар мэдлэг тутмаг учраас зөв санал өгөх тал дээр эргэлзсэн.

ХОЁРДУГААР ХЭСЭГ: Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөл шүүх байгууллагаас авсан судалгаа

Хүснэгт 21. Судалгаанд хамрагдсан шүүн таслах ажиллагааны оролцогч байгууллагын шүүгч, прокурор нарын тоо

Ажилласан жил	3-аас бага жил	5-10 жил	10-с дээш жил
Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нар	3	4	2
Хяналтын прокурор нар	8	6	1
Нийт судалгаанд хамрагдсан шүүгч нарын тоо	9		
Нийт судалгаанд хамрагдсан прокурор нарын тоо	15		

Төвийн 6 дүүргийн шүүгч нараас ирүүлсэн саналын талаар нэгтгэн хүргэлээ

Хууль зүйн туслалцааны төвийн талаарх мэдлэг, мэдээлэл шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн хувьд ямар байна вэ?

- Хууль зүйн туслалцааны төвөөс амьжиргааны төвшин доогуур иргэдэд улсын өмгөөлөгч үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг талаар иргэд төдийлөн мэддэггүй бөгөөд тухайн холбогдсон хэргийн мөрдөн шалгах ажиллагаа явагдсаны дараа шүүх дээр хавтаст хэрэг ирсэний дараа шүүх хурал

товлогдох үед энэ талаар мэдээлэл авах тохиолдол олон байдаг. Үүнээс болоод шүүх хурал хойшлох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах тохиолдол гардаг. Мөн шүүх байгууллагын хувьд зөвхөн улсын өмгөөлөгч нартай харьцаж ажилладаг учир тэдний хуульд заасан чиг үүрэг, явуулж буй үйл ажиллагааг мэдэхээс Хууль зүйн туслалцааны төв гэх байгууллагын талаар дэлгэрэнгүй мэдээлэл байхгүй.

- Улсын өмгөөлөгчдийн хувьд ажлын туршлагатай, шүүх хурал дээрээс ажиглахад мэтгэлцэх чадвартай, хариуцаж авсан хэрэгтээ ажил хэрэгч ханддаг.

Улсын өмгөөлөгч үйлчилгээ үзүүлж эхэлсэн нь төлбөрийн чадваргүй яллагдагчийн эрх ашгийг хамгаалахад ямар нөлөө үзүүлж байна гэж харж байна вэ?

- Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчилсөн, цаг хугацааны хувьд хэмнэлттэй байх боломжийг бүрдүүлж өгсөн. Хуучин зөвхөн хуульчдын холбоонд хандаж өмгөөлөгч авах хүсэлт гаргадаг байсан ба тэр болгон үнэгүй үйлчилгээ үзүүлэх өмгөөлөгч олддоггүй байсан. Харин хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгч нар ажилладаг болсноор төлбөрийн чадваргүй иргэд өмгөөллийн үйлчилгээ авах боломж нээгдсэн.
- Төлбөрийн чадваргүй яллагдагч нарын хувьд хууль эрх зүйн туслалцаа авах ганц боломж нь улсын өмгөөлөгч нарын ажил, үйлчилгээ байдаг учраас яллагдагч нарын шүүхээр шүүлгэх, өмгөөлөгч авах эрхийг хангахад улсын өмгөөлөгчийн оролцоо маш чухал нөлөөтэй
- Зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчийг өмгөөлөх нь өөрөө хэргийн оролцогчдод адил бус боломж олгож байгаа хэлбэр. Учир нь хэргийн нөгөө талд мөн адил төлбөрийн боломжгүй, амьжиргаагаа залгуулах чадвартай байсан ч өмгөөлөгч авах боломжгүй хохирогч нар олон байдаг. Тэднийг өмгөөлөгч авах боломжоор яллагдагчийн адил хангах ёстой. Мөн зөвхөн эрүүгийн хэрэг, маргаан бус иргэн болон захиргааны маргаан дээр ч амжиргааны төвшин доогуур, өмгөөлөгч хөлслөх төлбөрийн чадваргүй хүмүүс олон байгаа.
- Хууль зүйн туслалцааны төвд ажиллаж буй зарим улсын өмгөөлөгчид ур чадварын хувьд төлбөрийн чадваргүй яллагдагчид үйлчилгээ үзүүлэхэд хангалттай хэмжээнд сайн байж чаддаггүй. Улсын өмгөөлөгчдийг шүүх хурлын үеэр ажиглахад шүүх хуралд хэлбэр төдий хандах, үйлчлүүлэгчийн эрх ашгийг хамгаалж хүсэлт, шаардлага тавих тохиолдол тун бага санагддаг.

Улсын өмгөөлөгчийг томилох процесс, иргэд улсын өмгөөлөгч авах ажиллагаа хэрхэн явагддаг вэ? Уг ажиллагаанаас болж шүүх хурал хойшлох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах тохиолдол байсан уу?

- Иргэдийн албан ёсны хаяг, түүний бүртгэлийн асуудлаас болоод хороо, дүүргээс бичиг баримт хөөцөлдөх тал дээр нилээн асуудал гардаг. Иргэдийн иргэний үнэмлэх дээрх албан ёсны хаяг нь бүр хөдөө аймгийнх мөртлөө хотод оршин суудаг, түүнээс болоод хөдөөнөөс бичиг баримт бүрдүүлэх шаардлага гардаг, гэх зэрэг шалтгаанаас болоод улсын өмгөөлөгч авах процесс удаашрах тохиолдол гардаг. Үүнийг заавал сум, хорооны засаг даргаас тодорхойлолт шаардахгүйгээр хялбар аргаар (цахим хэлбэрээр...) харьяалал харгалзахгүй авдаг болбол улсын өмгөөлөгч авах процессыг илүү хөнгөвчилнө.
- Төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн туслалцаа үнэ төлбөргүй үзүүлж байгаатай адил хохирогчид ч энэ боломжийг нээж өгөх ёстой. Мөн түүнчлэн хохирогчид улсын өмгөөлөгч авах боломжийг олговол энд заавал амжиргааны төвшин доогуур байх гэсэн шаардлага тавих хэрэггүй. Учир нь зөвхөн амжиргаагаа залгуулах хэмжээний орлоготой, өндөр төлбөртэй өмгөөлөгч авах боломжгүй олон хохирогчид байгаа. Эдгээр хүмүүст өмгөөллийн үйлчилгээ авах боломжийг нээх ёстой. Ингэснээр шүүн таслах ажиллагаа тасралтгүй явах боломжтой

Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг сайжруулах санал

- Зөвхөн яллагдагчид бус төлбөрийн чадваргүй хохирогчид мөн үйлчилгээ үзүүлдэг болох, улсын өмгөөлөгчийг иргэд авах процессыг хялбарчлах, хаягийн зөрчилтэй иргэдэд улсын өмгөөлөгч авах боломжийг нээж өгөх, өмгөөлөгч нарын орон тоог нэмэгдүүлэх
- Насанд хүрээгүй хохирогчид хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх тал дээр дүүргийн гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн хэлтэс ажилладаг боловч хангалттай хүүхдийн эрх, ашгийг хамгаалж чаддаггүй. Хууль зүйн туслалцааны төв тус байгууллагатай хамтран ажиллаж насанд хүрээгүй хохирогчийн эрх ашгийг хамгаалах тал дээр улсын өмгөөлөгчийг ажиллуулах хэрэгтэй.
- Эрүүгийн хэргийн тоо, улсын өмгөөлөгч авч буй иргэдийн тоо зэргээс хархад улсын өмгөөлөгч нарын ажлын ачаалал маш өндөр байх бөгөөд тэдний орон тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарч ажиллах хэрэгтэй гэсэн саналтай байна.
- Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчийн талаар иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны ажлыг түлхүү хийх хэрэгтэй. Мөн цагдаа, прокурорын байгууллагад ч хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагаа, улсын өмгөөлөгчдийн ажил, мэргэжлийн талаар тодорхой хэмжээнд сургалт, сурталчилгаа хийх шаардлагатай гэж үзэж байна.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд “хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа” гэж нэр томъёо байдаг. Энэ нь бусдаас хөлс авахгүйгээр нийтийн тусын тулд болон нийгмийн эмзэг хэсгийн эрх, хууль ёсны

ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах зорилгоор үзүүлж байгаа хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээг хэлэх ба Монголын хуульчдын холбоонд “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо” гэж ажилладаг. Тус хорооны үйл ажиллагаа нь “Хууль зүйн туслалцааны төвийн гол чиг үүрэгтэй давхардсан гэж харж байна. Эдгээр чиг үүргийн давхардлыг нэгтгэх хэрэгтэй. Нэг талаар улсын өмгөөлөгч нар зөвхөн яллагдагч нарт өмгөөлөл үзүүлж байгаа нь зарим хүнд гэмт хэрэгт холбогдсон эсхүл олон удаа гэмт хэрэг үйлдэж байгаа яллагдагч нарт шүүн таслах ажллагааг өөрч ашигтайгаар эргүүлэх боломж олгоод зогсохгүй нийгэмших засан хүмүүжих боломжийг үгүй хийдэг. Учир нь гэмт хэрэгтэн хууль бус үйлдэл хийснийхээ үр дүнд ашиг хонжоо олдог ч төлбөрийн чадваргүй гэсэн үндэслэлээр улсын өмгөөлөгчөөр өмгөөлүүлж байгаа нь түүнд дахин гэмт хэрэг хийж боломжоор хангаж байна.

Алслагдмал 3 дүүргийн шүүгч нараас ирүүлсэн саналын талаар нэгтгэн хүргэлээ

Хууль зүйн туслалцааны төвийн талаарх мэдлэг, мэдээлэл шүүхээр үйлчлүүлж буй иргэдийн хувьд ямар байна вэ?

- Шүүх дээр ирж буй иргэдийн хувьд улсын өмгөөлөгчийн талаар мэдлэг мэдээлэл харилцан адилгүй байна. Зарим нь шүүхэд ирээд амьжиргааны төвшин доогуур, төлбөрийн чадваргүй иргэдэд улсын өмгөөлөгч үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг талаар мэддэг бол зарим нь мөрдөн байцаалтын шат, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны үеэс улсын өмгөөлөгчөөс хууль зүйн туслалцаа авсан иргэд байдаг.
- Алслагдмал дүүрэг учраас амжиргааны төвшин доогуур өрх дийлэнх хувийг эзэлдэг. Тухайн долоо хоногийн нийт зарлагдсан шүүх хурлын 50%-д улсын өмгөөлөгч оролцсон байгаа талаар шүүх хурлын оролцогч болон тэдгээрийн өмгөөлөгчийн талаар дэлгэрэнгүй хувиариас харагдаж байсан .
- Шүүх байгууллагын шүүгчийн хувьд зөвхөн улсын өмгөөлөгч нартай шүүх хурлаар дамжуулан харилцдаг учир хууль зүйн туслалцааны төвийн талаар, үйл ажиллагааны тухай дэлгэрэнгүй мэдээллийг байдаггүй . Харин амжиргааны төвшин доогуур, төлбөрийн чадваргүй иргэдэд улсын өмгөөлөгч нар хууль, эрх зүйн үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлдэг талаар иргэд тэр бүр мэддэггүй ба шүүх дээр ирсэн хойноо улсын өмгөөлөгчийн талаар мэдэж, өмгөөлөгч авах хүсэлт гаргадаг нь шүүх хурал хойшлох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах шалтгаан болдог. Улсын өмгөөлөгч нар хэрэг үүссэнээс хойш мөрдөн байцаалтын шатнаас эхлэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцвол ач холбогдолтой.

Улсын өмгөөлөгч үйлчилгээ үзүүлж эхэлсэн нь төлбөрийн чадваргүй яллагдагчийн эрх ашгийг хамгаалахад ямар нөлөө үзүүлж байна гэж харж байна вэ?

- Багануур дүүргийн хэмжээнд нэг улсын өмгөөлөгч ажилладаг ба тус дүүргийн эрүүгийн шүүхээр шийдвэрлэгдэж байгаа нийт хэргийн 10 хувьд нь улсын өмгөөлөгч оролцдог учир төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль эрх зүйн үйлчилгээ үзүүлэх нь яллагдагчийн эрх ашгийг хамгаалахад чухал үр нөлөөтэй. Хэрэгт холбогдсон яллагдагч нарын хувьд дийлэнх нь бичиг үсэг мэдэхгүй, хууль эрх зүйн анхан шатны мэдлэггүй, төлбөртэй өмгөөлөгч авах боломжгүй хүмүүс байдаг учраас улсын өмгөөлөгч бол тэдний хувьд хууль эрх зүйн тусламж авах, эрхээ хамгаалуулах ганц субъект болдог.
- Дүүргийн улсын өмгөөлөгч нар нь шүүхэд шүүхийн нарийн бичиг, шүүгчийн туслахаар ажиллаж байсан ажлын туршлагатай хүмүүс учир шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагааны талаар хангалттай мэдлэгтэй бөгөөд ур чадварын хувьд жирийн төлбөр авч ажилладаг өмгөөлөгч нартай харьцуулахад дутахааргүй хангалттай чадвартай гэж ажиглагдсан

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу зөвхөн яллагдагчид үнэгүй үйлчилгээ үзүүлэх нь гэмт хэрэгт холбогдож буй бусад этгээдийн эрхийг хамгаалахад хангалттай гэж үзэж байна уу?

- Төлбөрийн чадваргүй, амьжиргааны төвшин доогуур яллагдагчид улсын өмгөөлөгч авах боломж олгодог атлаа яг адил амьжиргааны төвшин доогуур, төлбөрийн чадваргүй хохирогчид улсын өмгөөлөгч авах боломж хязгаарлагдмал байдгаас шалтгаалан хохирогч иргэд шүүх хуралд өмгөөлөгчгүй орох сонголтыг хийдэг. Тиймээс төлбөрийн чадваргүй хохирогч нарт өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх нь зайлшгүй шаардлагатай бөгөөд үүнийг дагаад улсын өмгөөлөгчдийн орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага мөн тулгарна.
- Улсын өмгөөлөгч нарыг насанд хүрээгүй болон бага насны хүүхэд гэмт хэргийн хохирогч болсон үед Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэс тухай хүүхдийн эрх хууль ёсны ашиг солнирхолыг хамгаалах үднээс ажилладаг. Гэхдээ тус байгууллага нь өмгөөлөгчтэй болгохдоо төлбөртэй өмгөөлөгчтэй хамтран ажиллах санал тавьдаг. Дээрх асуудлаар хууль зүйн туслалцааны төвтэй хамтарч ажиллах шаардлагатай гэж үзэж байна.
- Гэр бүлийн хүчирхийлэл нь нөхөр, эхнэрээсээ эдийн засгийн хараат байдалд орсон хохирогчид өмгөөлөгч авах төлбөрийн чадваргүй учир улсын өмгөөлөгч хууль зүйн туслалцаа үзүүлэх шаардлагатай болж байгаа юм. Гэхдээ хохирогчид улсын өмгөөлөгч заавал авах ёстой гэж тулгаж боломжгүй.

Улсын өмгөөлөгчийг томилох процесс, иргэд улсын өмгөөлөгч авах ажиллагаа хэрхэн явагддаг вэ? Уг ажиллагаанаас болж шүүх хурал хойшлох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах тохиолдол байсан уу?

- Дүүргийн төвдөө төрийн байгууллагууд нь төвлөрсөн байдаг учир иргэдийн хувьд амьжиргааны төвшин доогуур гэдгийг тогтоох тодорхойлолт, бусад улсын өмгөөлөгч авахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлэхэд тийм ч хүндрэлтэй биш.

Хууль зүйн туслалцааны төв, улсын өмгөөлөгчийн ажил, үйл ажиллагааг сайжруулах талаар танд хэлэх санал байна уу?

- Улсын өмгөөлөгч авахад иргэдийн амьжиргааны төвшинг үнэлдэг шалгуурыг өөрчлөх хэрэгтэй. Зарим иргэдийн хувьд өрхийн амьжиргаагаа залгуулах бага хэмжээний орлоготой ч өндөр төлбөртэй өмгөөлөгч авах боломж хомс байдаг. Тиймээс шүүх хуралд өмгөөлөгчгүй орох сонголтыг хийдэг бөгөөд шүүх хурлын үеэр өөрийн эрх, ашгийг хамгаалах хэмжээний хууль, эрх зүйн мэдлэг дутмагаас болж өөрийгөө хангалттай хэмжээнд өмгөөлж оролцож чаддаггүй харагддаг. Тиймээс хууль эрх, зүйн тусламж авах хэрэгцээтэй иргэдэд өнөөдөр маргаашийн амьжиргаагаа залгуулах хэмжээний орлогоос бус өмгөөлөгч авах санхүүгийн чадавхаас хамаарч улсын өмгөөлөгч нар өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг болох хэрэгтэй.

Дээрх судалгаанд дурдагдсан эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч нараас авсан судалгааны нэгдсэн дүгнэлт

Шүүх хуралд орохоор ирж буй иргэдийн хувьд хууль зүйн туслалцааны төв болоод улсын өмгөөлөгчийн талаар мэдээлэлгүйгээсээ болоод мөрдөн шалгах ажиллагаа явагдсаны дараа шүүх хурлын шатанд өмгөөлөгч авах хүсэлт гаргадаг бөгөөд энэ нь эргээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, шүүх хурал хойшлуулах шалтгаан болдог. Улсын өмгөөлөгч нарын хандлага, ёс зүйн тухайд зарим өмгөөлөгч нар хэрэгт хайнга хандах, шүүх хуралд дүр үзүүлсэн өнгө аястай оролцох тохиолдол ажиглагддаг боловч ур чадварын хувьд бүгд чадварлаг, олон жилийн ажлын туршлагатай сайн өмгөөлөгч нар ажилладаг гэж шүүгч нар дүгнэсэн байна.

Мөн түүнчлэн улсын өмгөөлөгч нарын ажлын хүрээг өргөтгөх тал дээр олон саналуудыг хэлж байсан ба зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх нь нийт төлбөрийн чадваргүй иргэдийн эрх ашгийг хамгаалахад хангалттай бус байгаа талаар хэлсэн юм. Түүнээс гадна дан ганц эрүүгийн хэрэг дээр улсын өмгөөлөгч ажиллуулах бус иргэн болон захиргааны маргаанд оролцож буй төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх хэрэгтэй байгааг онцолж байв.

Дээрхээс эсрэг байр суурьтай зарим шүүгч нар мөн байсан ба хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд заасан хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх агуулгатай чиг үүргийн хувьд давхацсан, тус байгууллагын чиг үүргийг хуульчдын холбоонд

шилжүүлж, энгийн төлбөр авч ажилладаг өмгөөлөгч нарын төлбөрийн чадваргүй иргэдэд хууль, эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх шаардлага, шалгуурыг нарийн болгох, түүгээр дамжуулан хуульч нарт шагнал, урамшуулал олгох системийг бий болгох ёстой талаар саналаа илэрхийлсэн.

Мөн улсын өмгөөлөгч авахад иргэдийн амьжиргааны төвшинг үнэлдэг шалгуурыг өөрчлөх хэрэгтэй талаар дурдсан ба зарим иргэдийн хувьд өрхийн амьжиргаагаа залгуулах бага хэмжээний орлоготой ч өндөр төлбөртэй өмгөөлөгч авах боломж хомс байдаг. Тиймээс шүүх хуралд өмгөөлөгчгүй орох сонголтыг хийдэг бөгөөд шүүх хурлын үеэр өөрийн эрх, ашгийг хамгаалах хэмжээний хууль, эрх зүйн мэдлэг дутмагаас болж өөрийгөө хангалттай хэмжээнд өмгөөлж оролцож чаддаггүй. Хууль эрх, зүйн тусламж авах хэрэгцээтэй иргэдэд өнөөдөр маргаашийн амьжиргаагаа залгуулах хэмжээний орлогоос бус өмгөөлөгч авах санхүүгийн чадавхаас хамаарч улсын өмгөөлөгч нар өмгөөллийн үйлчилгээ үзүүлдэг болох хэрэгтэй талаар дурдсан юм.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 2021 оны эхний 5 сард 4115 зөрчил бүртгэгдсэний 2975 (72.3 хувь) зөрчлийг шалган шийдвэрлэжээ. Гэр бүлийн хүчирхийллийн нийт бүртгэгдсэн зөрчил өмнөх оны мөн үеийнхээс 858 (17.3 хувь)-аар, шийдвэрлэсэн нийт зөрчил 857 (22.4 хувь)-гоор тус тус багассан байна.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн хэрэг 2021 оны эхний 5 сард 596 болж, өмнөх оны мөн үеийнхээс 129 (27.6 хувь)-өөр, эмэгтэй хүн оролцсон хэрэг 1322 болж, 65 (5.2 хувь)-аар нэмэгджээ. Харин согтуугаар үйлдсэн гэмт хэрэг 1742 болж, өмнөх оны мөн үеийнхээс 19 (1.1 хувь)-өөр, бүлэглэн үйлдсэн хэрэг 510 болж, 214 (29.6 хувь)-өөр, хүүхэд оролцсон хэрэг 217 болж, 23 (9.6 хувь)-аар, мансуурсан үедээ үйлдсэн хэрэг 68 болж, 4 (5.5 хувь)-өөр багасав.

Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн 596 хэргийн 61 (10.2 хувь) нь Монгол Улсын Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл (Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг)–ээр зүйлчлэгдсэн байна

ГУРАВДУГААР ХЭСЭГ: Хамтын ажиллагаа бүхий байгууллагын төлөөлөл прокурорын байгууллагаас авсан судалгаа

Хууль зүйн туслалцааны төвийн талаарх мэдлэг, мэдээлэл иргэдийн хувьд ямар байна вэ?

- Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааг бол нарийн сайн мэдэхгүй. Зөвхөн улсын өмгөөлөгч нар ажилладаг гэдгээр нь л мэддэг. Харин иргэдийн дунд энэ талаар мэдлэг мэдээлэл дутмаг байгаа нь ажиглагддаг. Хэрэгт холбогдож ирээд цагдаа, эсвэл прокурорын байгууллагаас, зарим нь бүр шүүх дээр очсон үедээ л энэ талаар мэдээ мэдээлэл авч байдаг.
- Мөрдөгч, цагдаа нар хууль зүйн туслалцааны төвийн талаар, улсын өмгөөлөгчийн тухай иргэдэд хэрхэн тайлбарласнаас хамаарч иргэд мэдээ мэдээллийг олж авдаг. Түүнээс өөрсдөө хэрэгт холбогдохдоо эхнээсээ мэдээд улсын өмгөөлөгч авсан тохиолдол тун цөөхөн.

Улсын өмгөөлөгчийн ажлын ур чадвар, хэрэгт хандах хандлагыг шүүх хурлын шатанд дүгнэвэл?

- Улсын өмгөөлөгчтэй хэрэг дээр ологн таарч байгаагүй учир өмгөөлөгч нарын ур чадвар, мэдлэгийг хувь хүнийх нь хувьд дүгнэлт хийх боломжгүй байна. Өмгөөлөгч нарын ур чадвар нь тэдний мэдлэг, ажилласан туршлагаас хамаараад янз бүр байдаг тул хөндлөнгөөс дүгнэлт хийхэд хүнрэлтэй.
- Улсын өмгөөлөгч нар ур чадвар, мэргэшлийн хувьд жирийн төлбөртэй өмгөөлөгч нартай харьцуулахад хангалттай хэмжээнд биш. Улсын өмгөөлөгчөөр ажиллаж буй өмгөөлөгч нарыг хархад тогтмол цалингийн эх үүсвэртэй болох хүсэлтэй, эсвэл өмгөөллийн салбарт туршлага хуримтлуулахаар орж ирж буй шинэ залуу өмгөөлөгч нар байгаа харагддаг
- Улсын өмгөөлөгчдийн мэдлэг ур чадвар, хэрэгт холбогдсон төлбөрийн чадваргүй яллагдагчийн эрх ашгийг хамгаалах хэмжээнд хангалттай сайн гэж дүгнэж болно. Гэхдээ зарим өмгөөлөгч нарийн хувьд хэрэгт хайнга хандах, шүүх хуралд хэлбэр төдий оролцох тохиолдол бага зэрэг ажиглагддаг

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу зөвхөн яллагдагчид үнэгүй үйлчилгээ үзүүлэх нь гэмт хэрэгт холбогдож буй бусад этгээдийн эрхийг хамгаалахад хангалттай гэж үзэж байна уу?

- Зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлнэ гэдэг нөгөө талаар хохирогчийн эрх ашгийг хамгаалах шаардлагыг мөн бий болгож байгаа юм. Гэтэл одоо байгаа “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулиар зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагчид эрүүгийн хэрэг дээр хууль эрх

зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлж байгаа бөгөөд үүнтэй адил төлбөрийн чадваргүй, өмгөөлөгчийн хөлс төлөх боломжгүй хохирогч нарт өмгөөлөгч авах боломж, бололцоог олгох нь зүйтэй.

- Зөвхөн амжиргаагаа залгуулах төдий орлоготой хохирогч нар улсын өмгөөлөгч авах боломжгүй, мөн төлбөртэй өмгөөлөгч авах боломжгүй нөхцөл байдлаас болж шүүх хуралд өмгөөлөгчгүй орох сонголт хийхээс өөр арга үгүй болдог.
- Улсын хэмжээнд гарч буй эрүүгийн хэргийн 1/5 нь Баянзүрх дүүрэгт харьяалагддаг учир гэмт хэргийн гаралтын тоо тус дүүрэгт өндөр. Үүнийгээ дагаад шүүхээр шийдвэрлэгдэж буй эрүүгийн хэргийн ачаалал өндөр бөгөөд төлбөрийн чадваргүй хэргийн оролцогчид ч дээрх үзүүлэлтэд хамаарч бусад дүүргийг бодуул харилцан адилгүй байна.
- Гэмт хэрэгт холбогдсон насанд хүрээгүй хохирогчийн хувьд итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хамт шүүх хуралд ордог ч тэр хүн нь ихэвчлэн эрх зүйн мэдлэг, мэдээлэлгүй гэр бүлийн хүн, эцэг эх нь байдаг. Тиймээс насанд хүрээгүй, өмгөөлөгч авах төлбөрийн чадваргүй хохирогчийг улсын өмгөөлөгч авах боломжоор хангах зайлшгүй шаардлагатай.

Улсын өмгөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль шатнаас орох хэрэгтэй гэж үзэж байна вэ?

- Мөрдөн байцаалтын шатнаас эхлээд хэрэгт оролцоод явбал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд, тухайн өмгөөлөгчөөр үйлчлүүлж буй иргдийн эрх ашгийн бүрэн хамгаалах боломжтой. Гэтэл зарим өмгөөлөгчийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаас, эсхүл өөр өмгөөлөгчийн ажиллаж байсан хэрэг дээр дундаас нь орох тохиолдол байдаг. Эдгээр асуудал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах, өмгөөлөгч нар хариуцсан хэрэгтээ хайнга хандах зарим шалтгаан болдог
- Гэмт хэргийн гаралт, ачааллаас хамаарч улсын өмгөөлөгчийн орон тоо хуваарилалтыг зөв тооцоолон хийх хэрэгтэй. Жишээлбэл дүүрэг, аймаг болгонд адил орон тоо бүхий улсын өмгөөлөгчид ажиллавал гэмт хэргийн гаралтын үзүүлэлтээс хамаарч зарим газар ачаалалтай, зарим газарт ачаалал багатай ажиллах нөхцөл бүрдэж энэ нь улсын төсвөөс адил цалин хөлс авдаг өмгөөлөгч нарын хувьд тэгш бус нөхцөлийг бий болгож байгаа юм.
- Мөн түүнчлэн зөвхөн эрүүгийн хэрэг бус зөрчил шалган шийдвэрлэх хэрэг дээр улсын өмгөөлөгчийг ажиллуулах шаардлагатай.
- Дээр хэлсэнчлэн хохирогч нарт мөн улсын өмгөөлөгч үйлчилгээ үзүүлдэг болбол өмгөөлөгч нарын ажлын орон тоог мөн нэмэгдүүлэх хэрэгтэй. Одоо улсын өмгөөлөгч нарын ажиллаж байгаа нөхцөлийг хархад зарим дүүрэгт ажиллаж

- байгаа өмгөөлөгч нар бусдыгаа бодвол хэд дахин их ачаалалтай ажиллаж байгаа. Тиймээс ажлын ачааллаас хамаарч улсын өмгөөлөгч нарын орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай.
- Сүхбаатар дүүрэгт ажилладаг улсын өмгөөлөгчдийн хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хуульд заасан чиг үүргийн дагуу идэвхтэй оролцдог. Ур чадвар, мэдлэгийн хувьд жирийн төлбөр авч ажилладаг өмгөөлөгч нартай харьцуулахад хангалттай сайн.
- Хэрэг үүссэнээс эхлээд тухайн хэргээ нэг өмгөөлөгч дагнан хариуцаж ажиллавал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой. Гэхдээ хэрэгт холбогдсон яллагдагч өмгөөлөгчөө солих хүсэлт гаргасан тохиолдолд өөр өмгөөлөгчөөр солих боломжийг мөн олгох нь зүйтэй.
- Хэрэг үүссэнээс эхлээд тухайн хэргээ нэг өмгөөлөгч дагнан хариуцаж ажиллавал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд ач холбогдолтой. Гэхдээ хэрэгт холбогдсон яллагдагч өмгөөлөгчөө солих хүсэлт гаргасан тохиолдолд өөр өмгөөлөгчөөр солих боломжийг мөн олгох нь зүйтэй.

Хууль зүйн туслалцааны төв, улсын өмгөөлөгчийн ажил, үйл ажиллагааг сайжруулах талаар танд хэлэх санал байна уу?

Хууль зүйн туслалцааны төв зөвхөн улсын өмгөөлөгчдийн биш өөрсдийн үйл ажиллагааг харуулсан сургалт сурталчилгааг иргэд болоод цагдаа, прокурорын байгууллагад илүү таниулах хэрэгтэй. Мөн түүнчлэн хууль зүйн туслалцаа шаардлагатай иргэдэд төлбөрийн чадвартай эсэхээс үл хамааран хууль зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө мэдээллийг хангалттай өгдөг байвал иргэдийн эрх зүйн мэдлэг дээшлэхийн хирээр шүүх, прокурорын байгууллагын ажлын ачааллыг бууруулахад төдий хэмжээнд нэмэр болно гэж бодож байна.

Улсын өмгөөлөгч нарын ажиллах хүрээг өргөсгөж, цалин, урамшууллын системийг чанаржуулах талаар анхаарч ажиллах хэрэгтэй.

- Хуульчдын холбоонд “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо” гэсэн сайн дурын хороо ажилладаг. Тус хорооны чиг үүрэг хууль зүйн туслалцааны төвийн чиг үүрэгтэй давхацсан гэж харж байна. Тиймээс давхар чиг үүрэг бүхий хууль зүйн туслалцааны төв гэсэн дагнасан байгууллага байх шаардлага байхгүй. Харин уг байгууллагад төвлөрч буй улсын төсвийн хөрөнгийг хуульчдын холбооны дээрх хорооны үйл ажиллагаанд зарцуулах хэрэгтэй.

- Улсын өмгөөлөгч нарын мэдлэг, ур чадварыг илүү чанаржуулахад анхаарах хэрэгтэй. Мөн хууль зүйн туслалцааны төвийн талаар, улсын өмгөөлөгчдийн үйл ажиллагааны тухай мэдлэг мэдээллийг иргэдэд сурталчлах ажлыг чанартай, идэвхтэй хийх хэрэгцээ шаардлага байгаа.

- Амьжиргааны төвшин тогтоох шалгуурыг өмгөөлөгч авах хэмжээнд тааруулж өөрчлөх хэрэгтэй. Учир нь улсын өмгөөлөгч авах хүсэлтэй хэдий ч амьжиргаагаа залгуулах хэмжээний орлоготой яллагдагч, хохирогч нар ч олон байдаг.
- Жирийн төлбөртэй өмгөөлөгчдийн хувьд сайн дураараа про-боно үйл ажиллагаа явуулах тохиолдол гардаг. Уг үйл ажиллагааг илүү эрчимжүүлж Иргэдэд хууль зүйн туслалцааны төв болоод улсын өмгөөлөгчийн ажил, мэргэжлийн талаар таниулах сургалт, сурталчилгааг чанартай хийх нь зайлшгүй шаардлагатай байна. Мөн улсын өмгөөлөгч авах процессыг тодорхой, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох ёстой.
- төлбөрийн чадваргүй иргэдэд өмгөөлөл үзүүлэх шаардлага, хэмжээг нэмэгдүүлж, түүгээр нь өмгөөлөгч нарыг өрсөлдүүлж, урамшуулал олгох тогтолцоотой болбол заавал хууль зүйн туслалцааны төв гэсэн бие даасан байгууллага байх шаардлагагүй болно.
- Мөн улсын өмгөөлөгчийг томилох процессыг хялбарчлах шаардлагатай. Төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд улсын өмгөөлөгч авахад шаардлагатай баримт бичгийг хөөцөлдөхөд хүндрэлтэй байдаг талаар олон сонсож байсан.
- Иргэдэд хууль зүйн туслалцааны төв болоод улсын өмгөөлөгчийн ажил, мэргэжлийн талаар таниулах сургалт, сурталчилгааг чанартай хийх нь зайлшгүй шаардлагатай байна. Мөн улсын өмгөөлөгч авах процессыг тодорхой, түргэн шуурхай, хүртээмжтэй болгох ёстой.

Алслагдмал 3 дүүргийн прокурорын байгууллагаас судалгаанд ирүүлсэн санал

Хууль зүйн туслалцааны төвийн талаарх мэдлэг, мэдээлэл иргэдийн хувьд ямар байна вэ?

- Иргэд улсын өмгөөлөгчийн талаар мэдээгүй ирэх тохиолдол олон гардаг. Энэ тохиолдолд шүүгч захирамж гаргаж түүний дагуу иргэд улсын өмгөөлөгчид хандаж шүүх хуралд оролцдог. Хууль зүйн туслалцааны төвийн талаар, үйл ажиллагааны талаар нарийн мэдэхгүй. Зөвхөн улсын өмгөөлөгч ажилладаг гэдгээр нь л мэддэг.
- Прокурорын хувьд хууль зүйн туслалцааны төвийн талаар, явуулж буй үйл ажиллагааны тухай нарийн сайн мэдэхгүй. Зөвхөн улсын өмгөөлөгч ажилладаг гэдгээр нь мэддэг.
- Иргэдийн хувьд цагдаа, прокурорын байгууллагаас эсвэл шүүхэд ирээд л улсын өмгөөлөгчийн талаар мэдээлэл авдаг.

Улсын өмгөөлөгчийн ажлын ур чадвар, хэрэгт хандах хандлагыг шүүх хурлын шатанд дүгнэвэл?

- Улсын өмгөөлөгч нь ажилдаа сэтгэлээсээ ханддаг бөгөөд энгийн төлбөр авч ажилладаг өмгөөлөгч нартай харьцуулахад ур чадварын хувьд дутахааргүй сайн.
- Улсын өмгөөлөгчдийн хувьд хэрэгт хандах хандлага тун тааруу, шүүх хуралд хэлбэр төдий оролцох тохиолдол олон ажиглагдсан.
- Улсын өмгөөлөгчид заавал ажилласан жил, туршлага заах шаардлагагүй. Шинэ залуу хуульчид олон ажиллаж байгаа ч тэдэнд сурч хөгжих, боломжийг бий болгох ёстой.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн дагуу зөвхөн яллагдагчид үнэгүй үйлчилгээ үзүүлэх нь гэмт хэрэгт холбогдож буй бусад этгээдийн эрхийг хамгаалахад хангалттай гэж үзэж байна уу?

- Мэдээж хангалттай биш. Шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хоёр талд яллагдагч хохирогч нар байдаг. Гэтэл зөвхөн төлбөрийн чадваргүй яллагдагч нар үнэ төлбөргүй өмгөөллийн үйлчилгээ авч байгаа нь хохирогчийн өмгөөлөгч авах эрхийг хангах хэрэгцээ шаардлага харуулж байна.
- Хангалттай бус бөгөөд хэргийн нэг тал болон оролцдог хохирогч нарт ч мөн адил улсын өмгөөлөгч авах боломжоор хангах хэрэгтэй. Мөн зөвхөн эрүүгийн хэрэгт бус иргэний хэрэгт ч төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа үзүүлэх улсын өмгөөлөгч ажиллах шаардлагатай.
- Ур чадвар, мэдлэгийн хувьд жирийн төлбөр авч ажилладаг өмгөөлөгч нартай харьцуулахад хангалттай сайн.
- Хэргийн нэг тал болж оролцож буй хохирогчид улсын өмгөөлөгч авах боломжийг зайлшгүй олгох шаардлагатай.

Хууль зүйн туслалцааны төв, улсын өмгөөлөгчийн ажил, үйл ажиллагааг сайжруулах талаар танд хэлэх санал байна уу?

- Зарим сум дүүргийн хэмжээнд төлбөрийн чадвартай иргэд улсын өмгөөлөгч авах тохиолдол ажиглагддаг. Өөрөөр хэлбэл төлбөрийн чадваргүй яллагдагчид хууль эрх зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэх ёстой өмгөөлөгч нар хууль бусаар иргэдээс төлбөр авч өмгөөллийн үйл ажиллагаа эрхэлдэг гэсэн үг. Үүний цаана жинхэнэ төлбөрийн чадваргүй иргэдийн эрх ашиг хөндөгдөж байдаг. Тиймээс улсын өмгөөлөгч нарыг ямар хүний хэрэгт хэдэн удаа орж байгаа эсэх талаар хууль зүйн туслалцааны төв тодорхой шалгалт, шинжилгээг хийж хууль бус үйлдлүүдийг илрүүлэх хэрэгтэй гэж бодож байна.
- Улсын өмгөөлөгчдийн ажлын хүрээг өргөтгөх, мөн түүнийг дагаад орон тоог нэмэгдүүлэх шаардлагатай. Мөн өмгөөлөгч нарийн тогтвортой ажиллах

нөхцөлийг бүрдүүлэхийн тулд ажиллах нөхцөл, цалин урамшууллыг хангалттай болгох хэрэгтэй.

- Зарим салбарын хувьд нийт хүн амд ганцхан өмгөөлөгч ажилладаг учраас ачаалал ихтэй байгаа нь ажиглагддаг. Тиймээс өмгөөлөгч нарын орон тоог нэмэгдүүлэх тал дээр анхаарах хэрэгтэй.

Улаанбаатар хотын төвийн дүүргүүдэд ажиллаж буй хяналтын прокуроруудын хувьд хууль зүйн туслалцааны төв, түүний хийж хэрэгжүүлж буй үйл ажиллагааны талаар мэдээ мэдээлэл маш дутмаг байсан ба зөвхөн улсын өмгөөлөгч нар ажилладаг гэдгээр л мэддэг гэсэн хариулт өгч байсан юм. Үүнээс үзвэл хууль зүйн туслалцааны төв гэх байгууллага болоод түүний явуулж буй үйл ажиллагааны тухай иргэд төдийгүй прокурор, цагдаагийн байгууллагад ажиллаж буй албан хаагчидийн дундах мэдээ мэдээлэл бага байх ба энэ талаар сургалт, сурталчилгааны ажлыг илүү хийх хэрэгтэй тухай прокурорын газарт ажиллаж буй хяналтын прокурорууд хэлж байв.

Мөн улсын өмгөөлөгч нарыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны дундаас оролцуулах, ялангуяа шүүх хурлын шатанд өмгөөлөгч нар олноор солигдох нь яллагдагчийн эрх ашгийг бүрэн хамгаалж оролцох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түргэн шуурхай явуулах боломжийг хязгаарлаж байдаг талаар олон прокурор нар санал нэгтэй байсан ба улсын өмгөөлөгчийн ажиллаж буй хэргийг өөр өмгөөлөгчид шилжүүлэхгүйгээр дагнан ажиллуулах, мөн хэрэг үүссэнээс эхлээд мөрдөн байцаалтын шатанд өмгөөлөгч нарыг томилох нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд чухал ач холбогдолтой талаар дурдаж байв.

Үүнээс гадна гэмт хэргийн гаралт, ачааллаас хамаарч улсын өмгөөлөгчийн орон тоо хуваарилалтыг зөв тооцоолон хийх хэрэгтэй талаар дурдсан ба жишээлбэл дүүрэг, аймаг болгонд адил орон тоо бүхий улсын өмгөөлөгчид ажиллавал гэмт хэргийн гаралтын үзүүлэлтээс хамаарч зарим газар ачаалалтай, зарим газарт ачаалал багатай ажиллах нөхцөл бүрдэж энэ нь улсын төсвөөс адил цалин хөлс авдаг өмгөөлөгч нарын хувьд тэгш бус нөхцөлийг бий болгож байгаа тухай зарим прокурор нар хэлж байв.

Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т “улсын өмгөөлөгч нь хууль зүйн туслалцааг үйлчлүүлэгчид үнэ төлбөргүй үзүүлэх чиг үүрэгтэй”, 17.2.1-т “энэ хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хууль зүйн туслалцаа үзүүлэхийг улсын өмгөөлөгчид хориглох тухай” заасан байдаг. Гэтэл зарим дүүргийн хувьд төлбөрийн чадвартай иргэд улсын өмгөөлөгч авах тохиолдол байдаг ба танил тал, найз нөхдөөр дамжуулан улсын өмгөөлөгчийн талаар мэдээлэл олж авдаг. Мөн улсын өмгөөлөгч нар төлбөрийн чадваргүй иргэдээс гадна төлбөрийн чадвартай, өмгөөлөгчийн хөлс төлөх боломжтой иргэдээс төлбөр авч өмгөөллийн үйл ажиллагааг явуулдаг болохыг ажигласан тухай хяналтын прокурорууд хэлж байсан ба дээрхтэй адил

хууль бус үйлдлийг нээх илрүүлэх, энэ талаар нарийн хяналт, шалгалт явуулах хэрэгтэй талаар дурдсан байдаг.

ДӨРӨВДҮГЭЭР ХЭСЭГ: Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагаа болон удирдлагийн сэтгэл ханамж

1. Ажиллах орчны тав тух өмнөх жилийг бодвол сайжирсан

Хүснэгт 22. Ажиллах орчны тав тух өмнөх оныг бодвол сайжирсан эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш муу	6	12.8	12.8	12.8
	муу	4	8.5	8.5	21.3
	дунд	16	34.0	34.0	55.3
	сайн	10	21.3	21.3	76.6
	маш сайн	11	23.4	23.4	100.0
	Total	47	100.0	100.0	

Дээрх асуулгад нийт судалгаанд оролцсон өмгөөлөгчийн 21 буюу 44.6 хувь нь хангалттай сайжирсан гэж дүгнэсэн бол үлдсэн хэсэг буюу 55.6 хувь нь ажиллах орчны хувьд өнгөрсөн жилээс өөрчлөгдөөгүй, илүү муу байгаа гэж дүгнэсэн байна.

2. Ажил хийхэд шаардлагатай техник хэрэгсэл, унаа, утасны зардал хангалттай олгогддог

Хүснэгт 23. Ажил хийхэд шаардлагатай техник хэрэгсэл , унаа, утасны зардал хангалттай олгогддог эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш муу	21	44.7	44.7	44.7
	муу	11	23.4	23.4	68.1
	дунд	9	19.1	19.1	87.2
	сайн	5	10.6	10.6	97.9
	маш сайн	1	2.1	2.1	100.0
	Total	47	100.0	100.0	

Уг асуулгад нийт судалгаанд хамрагдсан өмгөөлөгчдийн 5 буюу ердөө 10 хувь нь хангалттай олгогддог гэж дүгнэсэн бөгөөд бусад өмгөөлөгчдийн хувьд

ажил хийхэд шаардлагатай зардлыг хангалттай олгодоггүй гэж дүгнэсэн байдаг. Ихэнх өмгөөлөгчдийн хэлж байгаагаар тэдэнд утас болоод, унаа, томилолтын зардал огт олгогддоггүй бөгөөд хөдөө орон нутгийн өмгөөлөгчдийн хувьд сумдын шүүх, прокурорын газар руу байнга явах хэрэгцээ тулгардаг талаар дурдаж байсан юм.

3. Удирдлагын ажлын арга барилын тухай

Хүснэгт 24. Удирдлагын удирдах арга барил таны бодлоор

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	сайн	23	48.9	48.9	48.9
	дунд	24	51.1	51.1	100.0
	Total	47	100.0	100.0	

Хууль зүйн туслалцааны төвийн дарга, удирдлагын ажлын арга барилыг нийт өмгөөлөгчдийн 22 буюу 46.8 хувь нь сайн, боломжийн гэж дүгнэсэн бол 25 буюу 53 хувь нь дунд гэсэн үнэлгээг өгсөн байна. Мөн хууль зүйн туслалцааны төвийн удирдлагууд байнга солигддог, тогтвортой бус байдаг тухай, хуульч, эрх зүйч мэргэжилтэй, өмгөөлөгчөөр ажиллаж байсан ажлын туршлагатай хүн ажиллах шаардлагатай талаар дурдаж байв.

Би өмгөөлөгчөөр ажиллаад 2 жил болоход гурван даргын нүүр үзсэн. Хууль зүйн туслалцааны төвийн удирдлага нар байнга солигддог, тогтвортой бус.

Хууль зүйн туслалцааны төвийн улсын өмгөөлөгчийн ярилцлагаас

4. Улсын өмгөөлөгч нарын эдийн засгийн баталгаа хангалттай эсэх

Хүснэгт 25. Таны Эдийн засгийн баталгаа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	тийм	3	6.4	6.4	6.4
	үгүй	44	93.6	93.6	100.0
	Total	47	100.0	100.0	

Дээрх асуулгад 3 өмгөөлөгч эдийн засгийн баталгаа хангалтай гэж дүгнэсэн бөгөөд үлдсэн хэсэг буюу нийт өмгөөлөгчдийн 93 хувь нь хангалттай биш гэж дүгнэсэн байна. Судалгаанд хамрагдсан нийт өмгөөлөгчдийн дийлэнх хувь нь цалин хангамж бага байгаа, улсын өмгөөлөгч нарын нийгмийн болоод эдийн засгийн баталгааг нэмэгдүүлэх шаардлагатайг онцолж байв.

5. Хийгдэж байгаа ажлын ачаалал, гүйцэтгэлийн үр дүнд тохирсон цалин, урамшуулал өгдөг

Хүснэгт 26. Хийгдэж байгаа ажилдаа тохирсон цалин авч байгаа эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш муу	20	42.6	42.6	42.6
	муу	11	23.4	23.4	66.0
	дунд	14	29.8	29.8	95.7
	сайн	2	4.3	4.3	100.0
	Total	47	100.0	100.0	

Улсын өмгөөлөгч нараас дээрх асуулгаар судалгаа явуулж 1-5 хүртэлх оноогоор дүгнүүлэхэд 5 буюу хангалттай сайн цалин, урамшуулал олгодог гэж дүгнэсэн өмгөөлөгч байгаагүй бөгөөд нийт өмгөөлөгчдийн 9 буюу 19.1 хувь нь 3-4 оноо, үлдсэн 80.8 хувь нь 1-2 оноогоор дүгнэсэн байна.

6. Хэрэгтний нууцлалыг хадгалах тал дээр ажиллах орчин шаардлага хангасан эсэх

Хүснэгт 25. Хэрэгтний нууцлалыг хадгалах тал дээр ажиллах орчин шаардлага хангасан эсэх

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш муу	9	19.1	19.1	19.1
	муу	4	8.5	8.5	27.7
	дунд	12	25.5	25.5	53.2
	сайн	12	25.5	25.5	78.7
	маш сайн	10	21.3	21.3	100.0
	Total	47	100.0	100.0	

Судалгаанд хамрагдсан нийт өмгөөлөгчдийн 20 буюу 42.5 хувь нь үйлчлүүлэгчийн хувь хүний нууцыг хадгалах тал дээр ажлын өрөө, байр сууц нь хангалттай шаардлагад нийцсэн гэж дүгнэсэн бол үлдсэн 27 буюу 57.4 хувь нь хангалттай биш гэж дүгнэсэн байна. Мөн зарим орон нутагт ажиллаж буй өмгөөлөгчдийн хэлж байгаагаар улсын өмгөөлөгчийн бие даасан байр, өрөө тасалгаагүйн улмаас жижиг, хүн ам багатай газар нутагт хувь хүний нууцад халдах, задруулах эрсдэл үүсэж болзошгүй гэсэн байдаг.

Миний хувьд аймгийн худалдааны төвийн нэг өрөөнд өөрийн ажил хэргийг явуулдаг ба үйлчлүүлэгчтэйгээ уулзах, зөвлөгөө өгөх үед хувь хүний нууцтай холбоотой чухал яриа тэнд өрнөдөг. Гэтэл худалдааны төвд байрладаг учир арилжаа, наймаа хийж байгаа хүмүүс олноор цуглардаг, хүмүүсийн яриа дуу чимээ тод сонсогддог учир өрөөнд яригдаж буй мэдээлэл гадагшаа задрах эрсдэлтэй нөхцөлд ажилладаг.

Орон нутагт ажиллаж буй улсын өмгөөлөгчийн ярилцлагаас

7. Удирдлага нэгжийн дарга нарын хийж, хэрэгжүүлж буй үйл ажиллагаа

Хүснэгт 26. Удирдлага нэгжийн дарга нарын хийгдэж байгаа үйл ажиллагаа ямар байгаа талаа

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш муу	2	4.3	4.3	4.3
	муу	1	2.1	2.1	6.4
	дунд	12	25.5	25.5	31.9
	сайн	23	48.9	48.9	80.9
	маш сайн	9	19.1	19.1	100.0
	Total	47	100.0	100.0	

Хууль зүйн туслалцааны төвийн дарга, нэгжийн дарга нарын хийж хэрэгжүүлж байгаа ажил хэр байгаа тухай дээрх асуулгад дийлэнх өмгөөлөгчдийн хувьд сайн гэсэн үнэлгээг өгсөн бөгөөд 32 буюу 68.8 хувь нь 1-5, 15 буюу 31.9 хувь нь 1-3 оноогоор үнэлсэн байна

8. Сурч хөгжих, мэргэжлээ дээшлүүлэх боломж ажлын байранд сурч боловсрох, мэргэжлээ дээшлүүлэх боломжтой гэж хариулсан бол үлдсэн 57.4 хувь нь ажлын ачаалал, завгүй байдлаас болоод сурч хөгжих, сургалт семинарт хамрагдах боломж хомс байдаг гэж хариулсан байдаг.

Ажлын ачаалал, түүнд тохирсон бүтэц орон тоотой

Төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүргийг хэрэгжүүлэгч Хууль зүйн туслалцааны төв нь үйлчлүүлэгчийг зөвхөн яллагдагчаар хязгаарлахгүй. Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг /хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг/-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх, хүн худалдаалах, хүүхдийн эсрэг гэмт хэргийн хохирогч, хүүхдийн тэтгэлэг тогтоолгох болон Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан эрсдэлт нөхцөлд буй хүүхдэд мөн хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа үзүүлэхээр тогтоож, хамрах хүрээг өргөжүүлэн Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг боловсруулж УИХ-д хүргүүлсэн.

Сэлэнгэ аймаг дахь салбарын ахлах улсын өмгөөлөгч Г.Энхцэцэгийн ярилцагаас

Хүснэгт 27. Сурч хөгжих, мэргэжлээ дээшлүүлэх болоцоо хэр байна вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	маш муу	4	8.5	8.5	8.5
	муу	5	10.6	10.6	19.1
	дунд	18	38.3	38.3	57.4
	сайн	14	29.8	29.8	87.2
	маш сайн	6	12.8	12.8	100.0
	Total	47	100.0	100.0	

9. Судалгаанд нийт 47 улсын өмгөөлөгч хамрагдсанаас 20 буюу 42.5 хувь нь

Хүснэгт 28. Хэргийн ачаалал ямар байна вэ?

		Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid	бага	2	4.3	4.3	4.3
	дунд	15	31.9	31.9	36.2
	их	13	27.7	27.7	63.8
	маш их	17	36.2	36.2	100.0
	Total	47	100.0	100.0	

Орон нутагт ажиллаж буй өмгөөлөгчдийн хувьд хотын төвийн дүүргийн өмгөөлөгчидтэй харьцуулахад ажлын ачаалал багатай ч ажиллах орон тоо цөөхөн талаар дурдаж байсан ба хотын дүүргүүдээс судалгаанд хамрагдсан өмгөөлөгч нарын 10.6 хувь нь ажлын ачаалал багатай гэсэн үнэлгээ өгч үлдсэн 89.4 хувь нь хэргийн болон ажлын ачаалал өндөр байдаг гэж дүгнэсэн байна. Харин орон нутагт ажиллаж буй өмгөөлөгчдийн 12 буюу 25.5 хувь нь ажлын ачаалал багатай үлдсэн 35 өмгөөлөгч ачаалал өндөртэй ажилладаг гэж дүгнэсэн. Орон нутагт ганцаар ажилладаг өмгөөлөгч нарын хувьд хэргийн ачаалал багатай байдаг ч

зөвхөн хэрэг дээр ажиллахаас гадна, иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгөх, тайлан мэдээг бэлтгэх гээд олон ажлыг ганцаар хийдэг тул ачаалал өндөртэй талаар дурдаж байв.

10. Хууль зүйн туслалцааны төвийн цаашдын үйл ажиллагаанд өгөх санал

Хүснэгт 29. Цаашид ХЗТТ-д өгөх санал

	Frequency	Percent	Valid Percent	Cumulative Percent
Valid Ажиллах орчинг сайжруулах	9	19.1	19.1	19.1
Эдийн засгийн баталгаа сайжруулах	17	36.2	36.2	55.3
Эрх зүйн орчинг сайжруулах	13	27.7	27.7	83.0
Мэдлэг, ур чадвар дээшлүүлэх	8	17.0	17.0	100.0
Total	47	100.0	100.0	

Хууль зүйн туслалцааны төвд ажиллаж буй судалгаанд оролцсон нийт өмгөөлөгчдийн 34 хувь нь улсын өмгөөлөгч нарын нийгмийн болон эдийн засгийн баталгааг сайжруулах хэрэгтэй гэж үзсэн бол 21.2 хувь нь ажиллах орчинг сайжруулах, улсын өмгөөлөгчийн болоод туслахын орон тоог нэмэгдүүлэх тухай саналуудыг хэлж байв.

Мөн түүнчлэн эрх зүйн орчинг сайжруулах, улсын өмгөөлөгчийн ажлын статусыг тодорхой болгох, хууль зүйн туслалцааны тухай хуулийн төслийг батлуулах хэрэгтэй байгаа талаар өмгөөлөгчид санал нэгтэй байв.

Дээрхээс гадна улсын өмгөөлөгч нарын ур чадварыг нэмэгдүүлэх, мэргэжилээ дээшлүүлэх тал дээр боломж бололцоо олгох хэрэгтэй ба сургалт, семинарыг тогтоомол зохион байгуулах шаардлагатай талаар дурдсан юм.

ТАВДУГААР ХЭСЭГ . Дүгнэлт, зөвлөмж

5.1 Хууль зүйн туслалцааны төвийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд өмнөх онуудад тавьсан эрхэм зорилгод хүрч чадсан эсэх :

Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө нь зөрчигдсөн гэж үзвэл уул эрхээ хамгаалуулахаар шүүхэд гомдол гаргах, Монгол улсын үндсэн хуульд заасан "...өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах, нотлох баримтыг шалгуулах, шударга шүүхээр шүүлгэх, шүүх ажиллагаанд биеэр оролцох, шүүхийн шийдвэрийг давж заалдах, уучлал хүсэх эрхтэй...", Шүүгдэгч өөрийгөө өмгөөлөх эрхтэй. Шүүгдэгчид энэ эрхээ эдлэхэд хүсэлтээр нь буюу хуульд зааснаар хууль зүйн мэргэжлийн туслалцаа үзүүлнэ¹ гэж тус тус заасан. Тиймээс шүүн таслах ажиллагааг бүрдүүлэгч гурван тал болох Шүүх, Прокурор, өмгөөллийн байгууллагын эрх зүйн байдлыг хууль тогтоогч ердийн хуулиараа нарийвчлан тодорхойлохдоо тэнцвэртэйгээр зохицуулах ёстой. Харин өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд шүүн таслах ажиллагааны нэг тал болох өмгөөлөл, хууль зүйн туслалцааны эрх зүйн бусад хоёр тал болох шүүх, прокурортой харьцуулахад нь нэгдмэл бодлого хэрэгжилтийн түвшинд харилцан уялдаатай байж чадаагүй байна. Хэдийгээр хүн өөрийгөө өмгөөлөх эрх нь чөлөөтэй байдаг ч хүн бүрт энэ эрхээ эдлэх боломж, мэдлэг, ур чадвар, санхүүгийн хувьд харилцан адилгүй. Өмгөөллийн харилцааг зохицуулж буй хуулиудад хэдийгээр нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааг гэж зохицуулалт байгаа ч төлбөрийн чадваргүй иргэдэд үйлчлэх гол байгууллага нь Хууль зүйн туслалцааны төв гэх төрийн байгууллага байна.

Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 7.4.6-д зааснаар хууль зүйн туслалцааны үйлчлэх хүрээг өргөжүүлж, төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, зарим эрүүгийн хэргийн хохирогч, иргэний болон захиргааны зарим хэргийн төлбөрийн чадваргүй оролцогчийн хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах эрх зүйн орчныг бүрдүүлнэ гэж заасан² байдаг.

¹ Монгол улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14,50 дугаар хэсэг

² Монгол Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт- Монгол улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл- <https://legalinfo.mn/mn/detail/15584>

Үүний хүрээнд Засгийн газрын 263 дугаар тогтоолоор баталсан “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх Үндэсний хөтөлбөр” –ийг хэрэгжүүлж эхэлснээр амьжиргааны төвшин доогуур орлоготой, төлбөрийн чадваргүй иргэдэд хууль, эрх зүйн тусламж, үйлчилгээг хүргэх боломж нээгдсэн байдаг. Үүнээс хойш “Төлбөрийн чадваргүй яллагдагчид үзүүлэх хууль зүйн туслалцааны тухай” хуулийг 2013 онд Улсын Их Хурлаас баталж, 2014 оны 1 сарын 1-ээс хэрэгжиж эхэлснээр энэ талаарх эрх зүйн шинэчлэл хийгдэж эхэлсэн байна.

Мөн түүнчлэн 2021 оны 3 дугаар сард “Хууль зүйн туслалцааны тухай” хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Улсын Их Хуралд өргөн барьснаар улсын өмгөөлөгч нарын ажиллах хүрээ илүү нэмэгдсэн бөгөөд Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч хүүхэд, хүүхдийн тэтгэлэг гаргуулах төлбөрийн чадваргүй нэхэмжлэгч, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн төлбөрийн чадваргүй оролцогч, хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдэд үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай нарийвчлан тусгасан байна³.

³ Хууль зүйн туслалцааны тухай хуулийн төсөл- <http://forum.parliament.mn/projects/11049>

Улсын өмгөөлөгч нарын цалин хөлс, нийгэм, эдийн засгийн баталгаа

Цалин, хөлс, шагнал урамшууллын ёс зүйн үүрэг нь хуулийн байгууллагуудын хувьд ач холбогдлын түвшин өндөртэй юм. Хүний амь амьдралтай холбоотой чухал шийд гаргах үүрэгтэй албан хаагчийн хувьд цалин хөлсний хэмжээ өндөр байснаар ёс зүйн өндөр түвшинд ажиллах шаардлага тавигдаж, хүний нөөц бүрдүүлэлтийн шалгуурыг өндөрсгөж чадварлаг боловсон хүчнийг шинээр авах, хуучин чадварлаг ажилтнаа тогтоон барих гол хүчин зүйл болдог. Өнөөгийн зах зээлийн хэрэгцээнд улсын өмгөөлөгчийн цалин хөлс хүрэлцэхгүй нөхцөл байдал нь улсын өмгөөлөгч төрийн албанд төрийн чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байгаа ч ижил түвшний албан хаагчтай адил цалин, шагнал, урамшууллыг авч чадахгүй байгаа нь улсын өмгөөлөгчийг тогтвор суурьшилтай ажиллуулах, үйлчилгээний чанарыг сайжруулах, тэдний цалин, урамшууллыг тодорхой хэмжээнд нэмэгдүүлж бусад хуульчдын цалингийн жишигт нийцүүлэх хэрэгцээ шаардлагыг үүсгэж байна. Улсын өмгөөлөгчийн цалинг шүүн таслах ажиллагааны бусад оролцогчийн түвшинд тогтоох нь төрөөс үзүүлж буй хууль зүйн туслалцааг чанаргүй, хүндээ хүргэж сэтгэл гаргахгүй ажилладаг гэх шүүмжлэлийг багасгах, өндөр ёс зүйтэй, чадварлаг хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал хүчин зүйл болно.

2020 оны хэрэглэгчийн үнэлгээний тайлангаас

Засгийн газрын 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай 427 дугаар тогтоолын дагуу албан хаагчдын цалинг Хууль зүйн туслалцааны төвийн захирлын 2020 оны “Төрийн албан хаагчдын цалинг шинэчлэн батлах тухай” А/01 дүгээр тушаалаар нэмсэн.

Нийт судалгаанд хамрагдсан улсын өмгөөлөгч нараас ажиллах орчин, нөхцөл, цалин хангамж өнгөрсөн жилээс сайжирсан тухай санал асуулгад 50 орчим хувь нь хангалтгүй үнэлгээг өгсөн бөгөөд цалин хангамжийн хүрэлцээгүй

байдал болоод ажиллах орчны тав тух, шаардлага хангахуйц биш гэж дүгнэсэн юм. Улсын өмгөөлөгч нь үндсэн цалингаас гадна нэмэгдэл хөлс, нөхөх олговор авдаггүй бөгөөд томилолт, утасны зардал, өдрийн хоол зэрэгт зарцуулах зардлыг өөрсдийн цалингаас гаргадаг тухай судалгаанд оролцсон өмгөөлөгч нар хэлж байв.

5.2 Бодлогын зөвлөмж

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 14 дэх хэсэгт “Монгол улсын иргэн... өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрхтэй... ” гэж заасан байх бөгөөд төлбөрийн чадваргүй иргэдийн хувьд хууль зүйн туслалцаа авах эрхээ эдлэх нэг боломж нь улсын өмгөөлөгч нараас үнэ төлбөргүй хууль, эрх зүйн зөвлөгөө, өмгөөллийн үйлчилгээ авах юм. Гэтэл шүүн таслах ажиллагааны бусад хоёр тал болох шүүх, прокурорын байгууллагын зарим албан хаагчдаас хууль зүйн туслалцааны төв байх шаардлагатай эсэх дээр эсрэг саналыг дэвшүүлсэн бөгөөд хуульчдын холбоонд бүртгэл бүхий бусад өмгөөлөгч нарын төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй тусламж үзүүлэх сайн дурын холбоодын үйл ажиллагааг дэмжих, өмгөөлөгч нарыг уг үйл ажиллагаагаар дамжуулан урамшуулах тогтолцоог бий болгох, хууль зүйн туслалцааны төвийн чиг үүргийг дээрх холбоодод шилжүүлэх саналыг гаргасан юм.

Гэвч хууль зүйн туслалцааны төвийн, улсын өмгөөлөгч нарын үйл ажиллагаа, үйлчилгээг авч буй иргэд жилээс жилд өсч байгаа бөгөөд өнгөрсөн 5 жилийн хугацаанд хууль зүйн туслалцааны төвөөс улсын өмгөөлөл авсан үйлчлүүлэгчдийн тоог үзүүлбэл:

Он	Тоо(хүнээр)
2017	2904
2018	3003
2019	3178
2020 оны 3 улирлын байдлаар	2528
2021 он	2399

Дээрх хүснэгтээс харвал жил ирэх тусам улсын өмгөөлөл авч буй хүмүүсийн тоо өссөн үзүүлэлттэй байх бөгөөд энэ нь төдий хэмжээгээр хууль зүйн туслалцааны төвийн ажиллах хэрэгцээ шаардлага байгааг харуулж байна. Мөн түүнчлэн сүүлийн жилүүдэд ковид-19 цар тахал гарсантай холбоотойгоор амьжиргааны төвшин доогуур хүмүүсийн тоо, ядуурлын хувь ихсэх төлөвтэй байх ба өнөөгийн нөхцөл байдалд ядуурлын хамралтын хүрээ хөдөөд 30.8 хувь, хотод 27.2 хувьтай байгаа нь ядуурлын төвшин хөдөөд хотоос өндөр байгааг, хууль зүйн туслалцаа, улсын өмгөөлөгч нарын хэрэгцээ шаардлага тэр хэмжээнд их байгааг илэрхийлж байна.

Улсын өмгөөлөгчийн үйл ажиллагааны чанар, хүртээмжтэй холбоотой асуудлаар харилцагч байгууллагуудын зүгээс өгч буй үнэлгээг харахад прокурорын байгууллагын хувьд хуулийн шаардлага ханган өмгөөлөгчийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны эхэн үе, мөрдөн байцаалтын шатнаас байлцуулах нь хамгийн чухал байгаа хэлсэн бол шүүхийн байгууллагын зүгээс зөвхөн яллагдагч төдийгүй гэмт хэргийн төрөл зүйлээс хамаарч төлбөрийн чадваргүй хохирогч, тухайн хэрэгт холбогдож буй иргэн бүрийн эрхийг хангахад анхаарах, улсын өмгөөлөгчдийн ур чадвар, цаг ашиглалтыг сайжруулахыг чухалчилж үзэж байгаа нь ажиглагдав. Харин аль аль байгууллагын зүгээс хууль зүйн туслалцааны хүртээмжийг дээшлүүлэх үүднээс улсын өмгөөлөгчдийн орон тоо, цалин хангамж, нийгмийн болон эдийн засгийн баталгааг нэмэгдүүлэх асуудлыг дэмжиж байв.

Зөвлөмж:

1. Өмгөөлөгч нарын орон тоог ажлын ачаалал, гэмт хэргийн гаралтын тоог харгалзан зөв хуваарилалт хийх, хүн ам багатай жижиг дүүрэг, аймгийн хувьд арай цөөн, харин хүн ам ихтэй төвийн том дүүрэг, аймгийн хувьд арай олон улсын өмгөөлөгч томилох зэргээр ажлын орон тоог зөв хуваарилах, үүнд чиглэсэн тооцоо судалгааг тогтмол хийх
2. Хэрэг анх үүссэн цагаас эхлэн тухайн хэрэгт холбогдогчийн өөрөө өөрийгөө өмгөөлөх, өмгөөлүүлэх эрхийг нь хангах үүднээс мөрдөн шалгах ажиллагааны явцад төлбөрийн чадваргүй иргэн болохыг тогтоох талаар тодорхой арга хэмжээг явуулах болон цагдаагийн байгууллагын ажилчидтай энэ талаар байнгын тогтвортой харилцаа холбоотой ажиллах шаардлагатай. Ингэснээр эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогчийн эрх хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад тодорхой хэмжээгээр хувь нэмэр оруулах боломжтой.
3. Иргэд болоод хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хүрээнд оролцдог шүүх, прокурор, цагдаагийн байгууллагуудад улсын өмгөөлөгчийн ажил үйл ажиллагаа, тэр дундаа хууль зүйн туслалцааны төвийн талаар дэлгэрэнгүй таниулах сургалт, сурталчилгаа, мэдээ мэдээллийг интернет орчин, сонин сэтгүүл, телевиз, радиогоор дамжуулж хүртээмжтэй зохион байгуулах. Мөн түүнчлэн дээрх байдлаар мэдээлэл авах боломжгүй төлбөрийн чадваргүй, амьжиргааны төвшнөөс доогуур орлоготой иргэдийн талаар нарийвчлан судалж тэдэнд өөрсдийн үйл ажиллагааг хэрхэн сурталчлах талаар арга аргачилгааг боловсруулж ажиллах. Ингэснээр хууль зүйн туслалцааны төвийн талаар мэдээ мэдээлэл иргэдийн болон төрийн байгууллагуудын ажилчин албан хаагчдийн дунд нээлттэй болох бөгөөд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хөнгөвчлөхөд чухал нөлөөтэй.

4. Нийт улсын хэмжээнд ажиллаж буй хууль зүйн туслалцааны төвийн өмгөөлөгч нарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь хууль дээдлэх, шударга ёсны зарчимд нийцэж буй эсэх талаар хагас жилд нэг удаа төв байгууллагаас хяналт тавьж, өмгөөлөгчийн ур чадвар, мэдлэгийг дээшлүүлэх үүднээс бүсчлэн зөвлөгөө, хэлэлцүүлгийг тогтвортой зохион байгуулах.
5. Хууль зүйн туслалцааны төвийн үйл ажиллагааны чиглэл, хэрэгжүүлж буй ажлын талаар дэлгэрэнгүй мэдээ мэдээлэл, явц дундын болон жилийн эцсийн тайлангийн талаар хууль зүйн туслалцааны төвийн албан ёсны цахим сайт болоод бусад интернет сүлжээн дэх цахим хаягуудад нээлттэй байршуулах.
6. Хууль зүйн зөвлөгөөний чиглэлээр төлбөрийн чадваргүй иргэд үйлчилгээ авах талаар хороо, багийн нийгмийн ажилтан, халамж үйлчилгээний ажилтантай хамтын ажиллагааны гэрээ байгуулж ажиллах.